



**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ
УДИРДЛАГЫН АЛБА**

2018 оны 10 дугаар
сарын 26-ны өдөр

№

Улаанбаатар хот

**“СОГТУУГААР ҮЙЛДЭГДЭЖ БАЙГАА ГЭМТ ХЭРЭГ”-ИЙН
НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА**

Судалгааны ажлын зорилго: Улсын хэмжээнд 2013-2017 онд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан нөхцлийг тогтооход оршино.

Дараах зорилтын хүрээнд судалгааны ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Гадаадын зарим улс орнууд дахь архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнд хяналт тавьж буй практик үр дүн, цаашдын чиг хандлага;
2. Монгол улсын архи, согтууруулах ундааны экспорт, импорт, дотоодын үйлдвэрлэл, борлуулалт, онцгой албан татварын өнөөгийн нөхцөл байдал;
3. Монгол улс дахь согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт, түүний харьцуулсан судалгаа болон гэмт хэрэг гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцлийн талаар;
4. Согтуугаар гэмт хэрэг үйлдэгсэдийн судалгаа;
5. Судалгааны ажлын үр дүнд тулгуурласан санал, зөвлөмж;

Судалгааны арга зүй: Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн статистик тоо, мэдээнд үндэслэн холбогдох баримт, судалгаанд анализ хийж, ярилцлага, ажиглалт явуулан, олон улсын байгууллагын судалгааны материал, гадаад орны туршлага, үүнтэй холбоотой гарсан нийтлэл, мэдээлэл зэргийг судалж, харьцуулалт хийн, санал дүгнэлт гаргах.

Судалгааны ач холбогдол: Согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцлийг Цагдаагийн байгууллагын сүүлийн 5 жилийн гэмт хэргийн статистик мэдээ, Үндэсний статистикийн газрын албан ёсны мэдээ, Татварын ерөнхий газрын мэдээ, холбогдох эрх зүйн акт зэргийг үндэслэн энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цаашид төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой тодорхойлох боломж бүрдэнэ.

**НЭГ. ДЭЛХИЙН ЗАРИМ УЛС ОРНУУДЫН АРХИ СОГТУУРУУЛАХ
УНДААНЫ ХЭРЭГЛЭЭ, ХЯНАЛТ, ЧИГ ХАНДЛАГА, АВЧ
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ**

Согтуурал нь хүн төрөлхтөний түүхэнд гэмт явдал, хүчирхийллийг өдөөж, хагацал, харамсал, хор хохирол, дагуулж байдаг нийгмийн сөрөг үзэгдэл юм.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын /ДЭМБ/ 2015 онд явуулсан судалгааны тайланд Ази тивийн улсуудыг архи, согтууруулах ундааны хэрэглээгээр нь Пакистан, Бангладеш, Индонез нь жилд нэг хүнд ноогдох архины хэмжээ 0.1- 0.6

л байгаа нь хамгийн бага хэрэглээтэй улс¹ гэж дурьдаад хамгийн их хэрэглээтэй улсуудыг байр эзлүүлж, жилд нэг хүнд ноогдох архины хэмжээг тодорхойлжээ.

1-рт - Бүгд Найрамдах Солонгос Улс /хүн ам 51 сая/²- 10.9 л

2-рт - Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс /хүн ам 85 сая/ - 8.7 л

3-рт - Тайландын вант Улс /хүн ам 67 сая / - 8.3 л

4-рт - Монгол Улс /хүн ам 3.1 сая/ - 7.8 л³

5-рт - Бүгд Найрамдах Хятад Ард Улс /хүн ам 1.36 тэрбум/ - 7,6 л хэрэглэдэг гэсэн байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тогтоосон стандартаар нэг хүнд жилд 8-9 литр архи, согтууруулах ундаа ноогдож байгаа тохиолдолд үндэсний аюулгүй байдалд эрсдэлтэй гэж тооцдог ажээ. Монгол улсад 2016 онд жилд нэг хүнд оногдох архи согтууруулах ундааны хэрэглээ **8.7 л болж өссөн⁴** гэсэн судалгаа гарсан байна.

Архины хэрэглээ хөгжингүй орнуудад буурч, харин хөгжиж буй орнуудад нэмэгдэн, жилд дэлхий нийтийн хэмжээнд архины улмаас 3.3 сая хүн нас барж, өвчний улмаас нас барсан хүмүүсийн 5.1 хувийг, нийт нас баралтын 5.9 хувийг, цаг бусын нас баралтын 3.2 хувийг архинаас үүдэлтэй гэж үзсэн байна.⁵

Дэлхийн өндөр хөгжилтэй ихэнх орнуудад архи согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, борлуулалт, сурталчилгаа нь өндөр хяналтын дор явагддаг бөгөөд Швед, Норвеги, Финланд, Исланд, Фарерын арал, Турк, Канад, Катар зэрэг улсуудад тусгай хуулийн дагуу зохицуулж, тодорхой нөхцлүүдийн үндсэн дээр худалдаалдаг. Тухайлбал: Швед улсад System Bolaget, Норвеги улсад Vinmonopolet, Финланд улсад Alko нэртэй худалдааны сүлжээг ашиглан, төрийн байгууллагын зохицуулалтаар, тусгай хяналтанд архийг зарж борлуулдаг байна.

Шведийн Вант Улсын эрх баригчид 1800-аад оноос хүн амын дунд архи, согтууруулах ундааны хэтрүүлэн хэрэглэлт, донтолт, өвчлөлт ихэссэн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар судалж, 1830-аад оноос архи, согтууруулах ундааг тусгай хяналтын доор худалдаалах санааг олж хэрэгжүүлж эхэлсэн байна. Улмаар 1900-аад оноос нэгдсэн зохион байгуулалтанд орж архины худалдааны эрх зүйн орчинг боловсруулан хэрэгжүүлсэн нь үр дүнгээ өгчээ. Согтууруулах ундаа худалдаалах тусгай дэлгүүрийн тоог тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоотой уялдуулан тогтоож, 2.2-3.5 хувьтай согтууруулах ундааг зөвхөн супермаркетэд худалдаалах бөгөөд хэтрүүлэн хэрэглэсэн буюу хэвийн бус байдалтай иргэнд худалдаалахыг хориглодог болжээ. Согтууруулах ундааг 3.5 хувиас бага градусын хатуулагтай бол 21 нас, 3.5 хувиас дээш градусын хатуулагтай бол 25 нас, бар, ресторан, уушийн газруудад 23 нас хүрсэн иргэнд тус тус үйлчилдэг байна⁶. Үйлчилгээний ажилчид үйлчлүүлэгчийн насанд хяналт тавих үүрэгтэй бөгөөд шаардлагатай үед тухайн иргэний насыг нотлох баримт бичгийг шалгаж, худалдаа үйлчилгээ хийдэг байна. Бүх төрлийн согтууруулах ундааг жижиглэнгээр худалдаалах, хямдрал зарлах, урамшууллын

¹ Montsame.mn сайт

² Википедиа чөлөөт нэвтэрхий толь

³ ДЭМБ-ын 2015 оны үзүүлэлтээр нэг хүнд ноогдох архины хэмжээ 7.8 л болж өссөн үзүүлэлттэй байна.

⁴ ДЭМБ-ын 2016 оны үзүүлэлтээр нэг хүнд ноогдох архины хэмжээ 8.7 л болж өссөн үзүүлэлттэй байна.

⁵ “Эрүүл мэнд, эдийн засагт учруулах архины дарамтыг судлах” судалгааны ажлын тайлан.

⁶ <https://en.wikipedia.org/wiki/Systembolaget>

системд оруулан /1ш авбал 1 үнэгүй, 1ш - 1.5 доллар, 2ш - 2.5 доллар гэх мэтээр/ худалдахыг хуулиар хорьжээ.

System Bolaget буюу архи худалдаалах тусгай зөвшөөрөлтэй дэлгүүр нь ажлын өдрүүдэд 09-18 цагт, бямба гарагт 11.00-13.00 цагт ажилладаг бол бар, ресторан 12.00-00.00 цагт согтууруулах ундаагаар үйлчилдэг. Согтууруулах ундааг онгоцны буудлын дэргэдэх татваргүй барааны дэлгүүрт зарж, борлуулахыг зөвшөөрөх бөгөөд аялалын автобус, задгай усан завь болон үүргийн худалдаагаар борлуулахыг хатуу хориглодог⁷ ажээ. Засгийн газраас худалдааны бүх цэгүүдэд үнийн хатуу монополь бодлого баримталдаг бөгөөд татварын хувь хэмжээг согтууруулах ундааны хатуулагыг харгалзан оногдуулдаг. Өндөр хатуулагтай архи, виски, коньяк зэрэгт 30-40 хувь, пиво, дарс, ликёрт 18-25 хувийн татвар тус тус оногдуулдаг ажээ. Өөрөөр хэлбэл 1 л согтууруулах ундааны (голдуу пиво) градус тутамд 1-1.66 крон⁸ ноогддог бол 12 хувийн 1л дарсанд 21.58 крон, 50 хувийн 1л архинд 250-500 кроны онцгой албан татварыг тус тус ноогдуулдаг байна. Согтууруулах ундааг зөвшөөрөлгүй борлуулсан иргэнийг 5000-10000 кроноор торгож, аливаа нийгмийн халамж, үйлчилгээ авах эрхийг 12-18 сараар хасдаг байна.

Насанд хүрээгүй иргэнд согтууруулах ундаагаар үйлчилсэн бол 8000-20000 кроноор торгож, энэ төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг 5 жил хүртэл хугацаагаар хасах, төлбөрийн чадваргүй бол албадан хөдөлмөр хийлгэдэг бол зөвшөөрөгдсөнөөс бусад цагт худалдвал 8000-20000 кроноор торгож энэ төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг 1-3 жил хүртэл хугацаагаар хасах, төлбөрийн чадваргүй бол албадан хөдөлмөр хийлгэдэг ажээ. Согтууруулах ундааг хуурамчаар буюу хууль бусаар үйлдвэрлэсэн, борлуулсан тохиолдолд 15000–25000 кроноор торгож, архи, согтууруулах ундаа худалдах, борлуулах, үйлдвэрлэх эрхийг 10-15 жилээр хасах арга хэмжээг тус тус авдаг байна.

Англи Улсад согтууруулах ундааны доод үнэ тогтоосноор гэмт хэргийн тоо жилдээ 12000-аар⁹, пивоны үнэ 10 хувиар нэмэгдэхэд оюутнуудын дундах харилцаанаас үүссэн маргаан 4 хувиар, согтууруулах ундааны татварыг хоёр дахин нэмэгдүүлснээр гэмт хэргийн түвшин 1.4 хувиар, АНУ-д согтууруулах ундааны татварыг нэмснээр хүүхдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг тус тус буурчээ¹⁰.

Австрали, Канад, АНУ, Норвегийн вант улс зэрэг улсад согтууруулах ундаа борлуулах цагийн хязгаарлалт тогтоосноор гэмт хэргийн тоо буурсан, харин согтууруулах ундаа борлуулах хугацааг уртасгаснаар залуучуудын согтууруулах ундааны хэрэглээ болон хүч хэрэглэх гэмт хэргийн тоо нь ихэссэн¹¹ гэсэн судалгааны дүн гарсан байна.

Оросын Холбооны Улсын Засгийн газар 2006 оноос хойш олон улсад хэрэгжүүлдэг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд тавих хяналтыг нэвтрүүлж, идэвхитэй шинэчлэл хийж ажилласнаар гэмт хэргийн гаралт

⁷ <https://www.concealedwines.com/business-opportunities-scandinavia-wine-producers/domestic-alcohol-policy-sweden-systembolaget/>


⁸ 1 доллар *7кр, 1 крон * 350 төгрөг

⁹ <https://www.drinkaware.co.uk/alcohol-facts/alcohol-and-the-law/the-law-on-alcohol-and-under-18s/>, Meier et al., 2008

¹⁰ https://en.wikipedia.org/wiki/Alcohol_licensing_laws_of_the_United_Kingdom

¹¹ <http://www.infoniagara.com/fastfacts/alcohol.aspx>. Wilkinson et al. 2016.


буурчээ. Үнийн бодлого ба борлуулалтын цагийн хязгаарлалт нь согтууруулах ундааны хэрэглээ, түүний сөрөг үр дагавруудыг бодитойгоор бууруулдаг бөгөөд гэмт хэргийн түвшинд шууд хамааралтай гэж үзэн¹² Засгийн газраас орон нутгийн удирдлагуудад согтууруулах ундаа борлуулах цагийн хуваарь тогтоох эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар үүрэг чиглэл өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байсан бөгөөд 2011 оноос хойш улс даяар хэрэгжиж, согтууруулах ундааг 23:00–08:00 цагт кафе, бааранд худалдаалахыг хориглож, үйлчилгээний газрууд ажлын өдрүүдэд 10:00-20:00 цагт үйлчилгээ явуулдаг болсноор гэмт хэргийн гаралт буурсныг Засгийн газраас явуулж байгаа согтууруулах ундааны бодлоготой хамааралтай гэж судлаачид дүгнэжээ.¹³



Зураг 1. ОХУ-ын гэмт хэргийн тоо, 100,000 хүнд ноогдохоор, 2003-2015¹⁴

Онцгой албан татвар сүүлийн 6 жилийн дотор нийтдээ хоёр дахин ихэссэнтэй холбоотой архины үнэ мөн адил хоёр дахин нэмэгдсэн¹⁵. Харин согтууруулах ундааны үнийн өсөлт нь гэмт хэргийн гаралтад нөлөө үзүүлдэггүй гэсэн судлаачдын дүгнэлт байдаг байна.

Албан ёсны статистик мэдээнээс харахад ОХУ-д 2016 онд нийт 2 сая гэмт хэрэг бүртгэгдсэнээс 400.000 буюу нийт гэмт хэргийн 20 орчим хувийг согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ үйлдсэн гэмт хэрэг¹⁶ эзэлж байна.



Зураг 2. ОХУ-ын Согтууруулах ундааны борлуулалт, төрлөөр, эзлэх хувь¹⁷

¹² (Babor et al, 2010). Carpenter, Dobkin, 2010; Popova et al, 2009; Wilkinson et al., 2016). Babor T, Caetano R, Casswell S, Edwards G, Giesbrecht N., Graham K., Rossow I. (2010)

¹³ (Carpenter, Dobkin, 2010; Popova et al., 2009; Wilkinson et al., 2016)

¹⁴ Wilkinson C, Livingston M., Room R. (2016). Impacts of changes to trading hours of liquor licences on alcohol-related harm: a systematic review 2005–2015. Public health research & practice, Vol. 26, No. 4. Retrieved from

¹⁵ (http://www.gks.ru/bgd/regl/b16_17/Main.htm).

¹⁶ https://xn--b1aew.xn--p1ai/upload/site1/document_news/009/338/947/sb_1612.pdf

¹⁷ http://www.gks.ru/wps/wcm/connect/rosstat_main/rosstat/ru/statistics/publications/catalog/doc_1135087342078

ОХУ-д 1990-2000 онд архины борлуулалт өндөр байсан хэдий ч сүүлийн жилүүдэд буурсаар байгаа бөгөөд эсрэгээрээ пивоны борлуулалт эрс нэмэгдсэн нь дээрх зургаас харагдаж байна.

Бүгд найрамдах Сингапур улсын Ерөнхий сайдаар 1959 онд томилогдсон Ли Куан Ю архины хэрэглээ ихтэй, арлын нэг жижигхэн улсын хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо эрх зүйн орчинг шинэчлэн, авлига хээл хахуултай тууштай тэмцэн, хүн бүрийг зорилготой, ажил орлоготой байлгах явдал юм гэж үзэн энэ чиглэлээр анхаарч ажиллажээ. Ядуу буурай энэ улсын хөгжлийн нууц нь иргэдийн ухамсарыг дээшлүүлж, эмх журамгүй байдлыг цэгцлэн, архи согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ, хэрэглээнд тавих хяналтыг нэмэгдүүлж, хууль зөрчигчдөд оногдуулах торгуулийн хэмжээг эрс өсгөсөн нь нийгмийн дэг журам тогтох үндэс болсон байна.

Аялал жуулчлал хөгжсөн энэ улс 2015 оноос архи согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ явуулах цагийг 22:30-07:00 хооронд тогтоосон бөгөөд зөвхөн бар, ресторан, кафе зэрэг тусгай зөвшөөрөлтэй газрууд ажилладаг байна. Хориглосон цагт архи согтууруулах ундаа хэрэглэсэн, бүх нийтийн амралтын болон баярын өдрүүдэд худалдаа явуулсан бол 1000 S\$¹⁸, давтан зөрчил гаргасан тохиолдолд 2000 S\$-аар тус тус торгох буюу 3 сар хүртэл хугацаагаар хорих, хориглосон цагт архи согтууруулах ундаа зарж борлуулсан аж ахуйн нэгжийг 10000 S\$ торгодог. Түүнчлэн 18 хүртэлх насны хүнд архи согтууруулах ундаа худалдах, худалдаж авахыг хориглодог бөгөөд худалдаа үйлчилгээ ихээр явуулдаг Литл Индиа болон Гейлан Сэрай гэх хоёр дүүрэгт хяналт шалгалтыг түлхүү тавьж ажилладаг байна. Мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодвол 5000 S\$ торгох эсхүл 6 сар хүртэлх хугацаагаар хорих бөгөөд давтан зөрчил гаргавал 10000 S\$ хүртэлх торгууль *оногдуулах эсвэл 12 хүртэлх сараар хорих ялаар* шийтгэдэг ажээ.

Архи согтууруулах ундааг хэрэглэх шаардлагагүй гэж үздэг Европын нэгэн улс бол **Исландчууд юм**. Бүгд найрамдах Исланд улс 350000 хүн амтай, иргэдийнхээ ажиллаж, амьдрах хууль эрх зүйн орчинг бүрэн хангасан улс юм. Исландын нийгмийн судалгаа шинжилгээний төвөөс 1998 онд хийсэн судалгаагаар 15-16 настангуудын 42 хувь нь архи ууж согтож үзсэн гэсэн судалгаа гаргасан бөгөөд үүний дагуу тус улсын нийслэл Рейкьявик хотын удирдлага, холбогдох албан тушаалтнууд, эцэг эхчүүд хамтран өсвөр үеийнхэний эрүүл хэвшлийн хувьсгал хийх 5 арга замыг¹⁹ хэрэгжүүлснээр өсвөр насныхны архины хэрэглээг бүрэн шийдвэрлэсэн Европын хамгийн аюулгүй хот юм. Худалдааны газруудад зөвхөн 2.5 хувийн алкогольтой шар айраг зардаг, өндөр агууламжтай согтууруулах ундааг зөвхөн зөвшөөрөгдсөн бааранд худалдаалдаг, үнийн хувьд хагас литр архи 100 ам.доллар байна. Согтууруулах ундааны татварыг хоёр дахин нэмэгдүүлэх нь гэмт хэргийн түвшинг бууруулдаг, согтууруулах ундааны борлуулалтын цагийн хязгаарлалт нь гэмт хэргийн түвшинд шууд хамааралтай талаар олон улсын 50 гаруй²⁰ судалгаануудад дурьджээ.

¹⁸ Сингапур доллар 1 S\$ * 1782,0 төгрөг

¹⁹ Trends.mn Исланд улс ирээдүйн иргэдээ ингэж анхаардаг нийтлэл.

²⁰ Wagenaar et al., 2010, Carpenter, Dobkin, 2010; Popova et al., 2009; Wilkinson et al., 2016.

**ХОЁР. МОНГОЛ УЛС ДАХЬ СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЭКСПОРТ,
ИМПОРТ, ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ,
ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТАЛААР**

Монгол улс дахь архи, согтууруулах ундааны экспорт, импорт, дотоодын архи согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний газруудын албан ёсны тоон мэдээллийг Монгол Улсын Үндэсний Статистикийн хорооноос авч, хүснэгт болон графикаар харууллаа.

Сүүлийн 5 жилд 5081 сая литр согтууруулах ундаа үйлдвэрлэж, 2325 сая литрийг импортолсон байна.

(мян.ам.долл/ thous. USD)

№	Барааны нэр	Хэм нэгж	Экспорт									
			2013 он		2014 он		2015 он		2016 он		2017 он	
			Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ	Тоо	Үнэ
Ус, ундаа, спирт, архи, дарс												
1	Пиво	л	90.0	0.7	6297.3	9.1	75438.2	75.1	162377.8	1183.0	329721.8	473.2
2	Усан үзэмний цэвэр дарс	л			1037.3	10.0	1560.0	13.7	1525.5	13.0	11161.5	57.5
3	Хөөсөрдөг дарс 35% хүртэл хатуулагтай	л			67.5	0.6			180.0	1.4	12.0	0.1
4	Ликер, виски, коньяк, архи	л	154926.5	1304.5	53053.4	394.6	17917.9	92.8	30195.0	141.8	14385.4	65.4
5	Коньяк	л					25.2	1.0				
6	Архи	л	136966.1	1061.9	52963.4	392.9	17892.7	91.8	30195.0	141.8	14379.4	65.3


Хүснэгт 1. Архи, согтууруулах ундааны экспортын хэмжээ, 2013-2017 он

Архи үйлдвэрлэгчид 2013-2017 онд нийт 2.523.966 литр архи, 2.704.782 литр ликер, виски, коньяк экспортолж, 5.556.2 мянган ам долларын орлого олсон гэсэн статистик дүн²¹ гарсан байна.

Монгол Улсын архи, согтууруулах ундааны 2013-2017 оны импортийн статистик мэдээллээс харахад пивоны хэмжээ жил дараалан буурч, архи, виски, ликерын хэмжээ өссөн, коньяк, дарсны импорт хэлбэлзэлтэй байгаа нь харагдаж байна.

Согтууруулах ундааны 2013 оны импортын хэмжээг 2017 онтой харьцуулахад жил дараалан багассаар 15.000 орчим ам.доллороор пивоны импорт буурсан, архи, коньяк, дарсны хэмжээ хэлбэлзэлтэйгээр нэмэгдэн, виски ликерны импорт нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


мян.ам.доллар. thous.USD



Зураг 3. Архи, согтууруулах ундааны импортын үнэ, 2013-2017 он

²¹ Үндэсний Статистикийн газрын тайлан

Спирт, шар айрагны үйлдвэр сүүлийн жилүүдэд жигд ажилласан бөгөөд архины үйлдвэр 2013 онд 62 байсан бол одоогоор архины 35, спиртийн 8, шар айрагны 17 нийт 60 үйлдвэр²² ажиллаж байна.




Зураг 4. Архи, согтууруулах ундааны дотоодын үйлдвэрийн тоо, 2013-2017 он

Архины 11 үйлдвэрийн тусгай зөвшөөрлийг 2017 онд түдгэлзүүлж, одоо нийслэлд 25, орон нутагт 10 үйлдвэр байна. Говьсүмбэр, Дорноговь, Орхон, Хэнтий, Сүхбаатар, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Ховд зэрэг 9 аймгийн архины үйлдвэр үйл ажиллагаагаа зогсоосон байна. Увс, Завхан, Архангай, Дундговь, Өмнөговь, Дорнод зэрэг аймагт тус бүр нэг үйлдвэр Говь-Алтай, Увс аймагт тус тус 2 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

Хувь хүний хэрэглээг хязгаарлахын зэрэгцээ үйлдвэрлэлд хязгаар тависнаар архидалттай тэмцэхэд тодорхой үр дүнд хүрэх боломжтойг Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Булган зэрэг аймгуудад үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт бусад аймгаас нэг дахин бага байгаагаас дүгнэж болохоор байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй “спиртийн үйлдвэрүүд хүч чадлынхаа 5 орчим хувийг, архины үйлдвэрүүд 68 гаран хувийг ашиглаж байгаа²³ талаар Монголын Хүнсчдийн холбооноос хийсэн судалгаанд дурьджээ. Согтууруулах ундаа үйлдвэрлэгчид монгол орны хөрсөнд ургасан улаан буудайн архийг дотооддоо худалдаалж ашиг олохоос илүүтэй экспортлох чиглэлээр орлогоо нэмэгдүүлэх боломжтой нь харагдаж байна.

мян.литр



Зураг 5. Үйлдвэрлэсэн архи, согтууруулах ундааны хэмжээ, 2013-2017 он

Спиртийг 2013 онд 99504 литрийг үйлдвэрлэж байсан бол сүүлийн 3 жилийн дундажаар 8700 орчим литр болж буурсан, дотоодын пивоны үйлдвэрлэл 2013 онд 637753 литрийг үйлдвэрлэж байсан бол жил дараалан өссөөр 824152 литр болж,

²² Үндэсний Статистикийн газрын www.1212.mn сайт

²³ “Исгэлтийн үйлдвэрлэл – зах зээлийн тойм” тайлангийн хураангуй. Монголын хүнсчдийн холбоо. УБ 2014 он

архины үйлдвэрлэл жигд буюу жилд дундажаар 23700 орчим литрийг үйлдвэрлэж, дарсны үйлдвэрлэлийн хэмжээ өссөн байна.

Хүнсний болон техникийн спиртийг согтууруулах ундааны үйлдвэрлэлд хэрэглэхээс гадна хүн болон мал эмнэлэг, хэвлэлийн үйлдвэр, арьс ширний үйлдвэр, барилга, тээвэр, хүнсний үйлдвэрийн хөргөлтийн машин, лабораториуд, гоо сайхан, нийтийн хоолны газар зэрэг салбарт тус тус өргөнөөр ашигладаг ажээ.

Архи, дарс, спирт, пивоны төрлөөр улсын төсөвт төлсөн онцгой албан татвар:

Онцгой албан татварын тухай хуулиар онцгой албан татвар ногдуулахдаа бүх төрлийн согтууруулах ундааны үйлдвэрлэгчийн борлуулсан барааны биет нэгж /литр/-ийг үндэслэн тогтоодог байна. Архи, дарс, спиртийн онцгой албан татвараас 2014-2017 онд 114.2-136.6 тэрбум төгрөг авахаас 129.0-160.3 тэрбум татвар, пивоны татвараас 22.0-28.0 тэрбум төгрөгийг авахаас 22.4-28.0 тэрбум төгрөгийн татварийг тус тус авсан байна.

Төрөл	Он	тэрбум төгрөг			
		2014	2015	2016	2017
Архи, дарс, спиртийн онцгой албан татвар	Төлөвлөгөө		131.2	114.2	136.1
	Гүйцэтгэл		129.0	138.4	146.8
	Хувь	117.3	98.3	121.2	107.9
Пивоны онцгой албан татвар	Төлөвлөгөө	24.0	22.7	19.1	22.0
	Гүйцэтгэл	28.0	23.7	136.6	24.8
	Хувь	116.3	104.5	160.3	112.7

Хүснэгт 2. Архи, дарс, спирт, пивоны төрлөөр улсын төсөвт төлсөн онцгой албан татварын хэмжээ, 2014-2017 он

Орлогын гүйцэтгэлийн дийлэнх буюу 98.0 хувийг үндэсний томоохон үйлдвэрлэгч болох “АПУ” ХК 52.8%, “Спирт бал бурам” ХК 29.2%, “Жем интернешнл” ХХК 15.4, “М Ти Эс” ХХК 0.5%, үлдэх хэсгийг орон нутгийн болон бусад татвар төлөгчдөөс төвлөрүүлсэн байна. 2014 онд 117.3%, 2015 онд 98.3%, 2016 онд 121.2 %, 2017 онд 107.9 %-ийн гүйцэтгэлтэй татвар төлжөө.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дэмжих, бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсний дагуу тамхи, согтууруулах ундааны онцгой албан татварыг үе шаттайгаар 2018 онд 10%, 2019 онд 5%, 2020 онд 5% хувиар тус тус нэмэгдүүлэхээр тооцсоноос харахад согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт нэмэгдэх²⁴ хандлагатай байна *литр*

Төрөл	2013	2014	2015	2016
Архи, дарс	9.6	9.2	7.8	8.7
архи	8.7	8.3	7.1	8.0
дарс	0.9	0.9	0.7	0.7
Шар айраг	33.1	29.8	29.7	29.6

Хүснэгт 3. Монголд жилд нэг хүнд ногдох согтууруулах ундааны хэмжээ 2013-2017 он

²⁴ Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлт.

Дэлхийд дундажаар 15-аас дээш насныханд оногдох архи, дарсны хэмжээ 6.2 литр байхад манайд 8.7 литр гэсэн 2016 оны статистик үзүүлэлт гарсан байна.²⁵ Дээрх үзүүлэлтээс харахад манай улсад архины хэрэглээ их байна гэж шууд дүгнэхээр байна.

Архи, дарс, шар айраг, спиртийн үйлдвэр болон 10000 хүн ам тутамд ногдох согтууруулах ундаа зарж, борлуулах зөвшөөрөлтэй цэгийн тоо, мөн нэг хүнд ногдох архи, согтууруулах ундааны хэмжээ зэргийг хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын сөрөг үзүүлэлтүүдэд хамруулдаг бөгөөд өмнөх жилээс 20-оос дээш хувийн бууралттай бол аюулгүй байдал хангагдсан гэж үздэг²⁶ ажээ.


Үзүүлэлт	Үйлчилгээ				Худалдаа			
	Зоогийн газар	Диско бар	Караоке	Кафе	Хүнсний дэлгүүр		Бөөний төв	Нийт
					Орон сууцны хороолол	Гэр хороолол		
2013 он	919	536	686	544	2368	4688	266	10007
2014 он	1473	630	1175	995	2012	4752	266	11303
2015 он	1114	419	788	718	2077	5003	284	10403
2016 он	1357	440	831	690	2171	4928	194	10611
2017 он	1001	432	850	780	2595	4840	197	10395

Хүснэгт 4. Согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо, 2013-2016 он

Нийслэлд 2017 онд архи согтууруулах ундаагаар худалдаа явуулах 3933, үйлчилгээний 2539, нийт 6472 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна²⁷.

ГУРАВ. СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улсын хэмжээнд 2013-2017 онд 139863 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсаны 28531 буюу 20.3 хувь нь согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзэлж байх бөгөөд 2014 оноос жил дарааллан 6.6-27.3 хувиар буурсан байна. Цагдаагийн байгууллагад 2013-2017 онд согтуугаар 28531 гэмт хэрэг бүртгэгдсэнийг жил, сар, өдөр, цагаар нь тооцолбол: жилд 5706, сард 475, өдөрт 16, цаг тутамд 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна. Нийслэлд 2013-2017 онд 14.084 гэмт хэрэг согтуугаар үйлдэгдсэн нь жилд 2816, сард 234, өдөрт 8, 3 цаг тутамд 1 хэрэг үйлдэгджээ. Орон нутагт 14447 гэмт хэрэг согтуугаар үйлдэгдсэн нь жилд 2889, сард 241, өдөрт 8, 3 цаг тутамд 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.




Зураг 6. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн байршил: 2013-2017 он

²⁵ Mofa.gov.mn. Монгол улсын Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлт.

²⁶ Эрүүл мэнд, эдийн засагт учруулах архины дарамтыг судлах судалгааны ажлын тайлан.

²⁷ Нийслэлийн цагдаагийн газрын танилцуулга


Цагдаагийн байгууллагад согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 50.3 хувь нь хөнгөн, 35.3 хүндэвтэр, 13.6 хувийг хүнд, 3.4 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж байна.



Зураг 7. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг Эрүүгийн хуулийн зүйлчлэлээр харуулбал, 2013-2017 он


Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 54.4 хувь нь Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 6.7 хувь нь Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг, 14.6 хувь нь Танхайрах гэмт хэрэг, 10.9 хувь нь Хулгайлах, 0.6 хувь нь Согтуугаар амиа хорлосон байна. Энэ хугацаанд 57 гадаадын иргэн согтуугаар гэмт хэрэгт холбогдон шалгагдаж, 30 хүн согтуугаар галт зэвсэг хэрэглэн гэмт үйлдсэн байна.

Нийт гэмт хэрэгт эзлэх хувиар




Зураг 8. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн ангилал: 2013-2017 он





Зураг 9. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн төрөл: 2013-2017 он

Амиа хорлох гэмт хэрэг 2013-2017 онд 1836 бүртгэгдсэний 368 нь согтуугаар амиа хорлосон байна.




Зураг 10. Согтуугаар амиа хорлосон хүн: 2013-2017 он

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос үйлдэгдсэн осол, согтуу явган зорчигч хохирсон үзүүлэлтийг харахад энэ төрлийн гэмт хэрэг жил дараалан буурсан бөгөөд Замын цагдаагийн албанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй ажил арга хэмжээ сайжирсан, зарим аймаг, сумдын нутаг дэвсгэрт явуулын хяналтын цэгийг нэмэгдлээр байрлуулсан, жолооч нарын хариуцлага, ухамсар дээшилсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистик мэдээнд бүртгэгдсэнээр 2013-2017 онд 1836 хүн амиа хорлосны 371 хүн согтуугаар амиа хорлосон байна. Прокурорын байгууллагаас хийсэн судалгаагаар 2012-2016 онд 2055 хүн амиа

хорлож нас барсаны 1729 эрэгтэй, 326 эмэгтэй, жилд дунджаар 411 хүн байна гэжээ. Өөрөөр хэлбэл эрчүүдийн амиа хорлолт эмэгтэйчүүдийнхээс 5.2 дахин их байна.²⁸



Зураг 11. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тархалт 2013-2017 он

Хүн ам ихтэй, нийтийн тээвэр хөгжсөн, архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг газар олонтой Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Хөвсгөл, Дорноговь, Дорнод аймгуудад согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 710-958 буюу хамгийн их үйлдэгдсэн байна.


Орон нутгийн цагдаагийн газар, хэлтсээс согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт ажил зохион явуулж байгаагаас онцлон дурьдвал: Баянхонгор аймаг архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулдаг газруудыг “Даваа” гаригт согтууруулах ундаагаар худалдаа явуулахыг хориглодог бөгөөд хяналтын талон тарааж, зөрчил, дутагдал гаргасан тохиолдолд талоныг цоолж, сунгалт хийхдээ харгалзан үзэх тухай Засаг даргын шийдвэр гаргасан нь гэмт хэрэг, зөрчил буурахад үр нөлөө үзүүлж байгаа ажээ. Говь-Алтай аймаг “Архигүй Алтайчууд” хөтөлбөр хэрэгжүүлж, нутгийн зөвлөл сум бүрээс архины асуудалтай 1 хүнийг сонгон жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж архины асуудлыг бүрэн шийдвэрлэвэл 10 сая хүртэл төгрөгийн урамшуулал олгох санал санаачлага гарган ажиллаж байгаагаас өөрөөр шинэлэг, үр дүн үзүүлэхүйц ажил зохион байгуулагдаагүй, орон нутагт архи согтууруулах ундааны үйлчилгээний цагийг өвлийн улиралд 22-00 цагт, зуны улиралд 00-02 цагт хязгаарлах шийдвэр гаргасан байна.

Нийслэлд 2013-2017 онд 14084 гэмт хэрэг согтуугаар үйлдэгдсэн бөгөөд Баянгол дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэс, Баянзүрх дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн харьяалах нутаг дэвсгэрт согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг их гарчээ. Учир нь архи, согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ явуулдаг газрууд

²⁸ УЕПГ-ын “Сургалт, судалгааны төв”-ийн Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор Б.Өнөрмаагийн судалгаа.


нэг дор хэт олноор төвлөрсөнөөс согтуурсан хүмүүс маргалдах, бусдын эрх чөлөөнд халдах, аж ахуйн нэгжүүд үйлчилгээний цагийг хэтрүүлэн ажиллах зэрэг зөрчил гаргаж, улмаар согтуугийн дуудлага, мэдээлэл ихтэй байдаг байна. Тодруулбал: БЗД-ийн зөвхөн 3-р хорооны нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ эрхэлдэг 42 аж ахуйн нэгж байгаагийн 23 буюу 54.7 хувь нь Сансарын үйлчилгээний төв орчимд, 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт 50 аж ахуйн нэгж байгаагийн 37 буюу 74 хувь нь Баянцээлийн гудамж дагуу байрладаг байна. Энэ хороонд 2017 онд 198 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар, гэмт хэргийн тухай гомдол, мэдээлэл 47.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.



БГД-ийн 1,2,3-р хороонд архины зөвшөөрөлтэй 45, 14, 15, 16, 17, 19-р хороонд 118 худалдаа үйлчилгээний газар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 140 бүртгэгдсэн нь олон нийтийн газарт согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас хоорондоо маргалдаж энэ төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгджээ. Үүнээс харахад үйлчилгээний цэгийн тоог хүн амын тоо, байршлыг харгалзан тогтоох зайлшгүй шаардлагатай байна. Архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулдаг цэг олонтой хороо, дүүрэгт үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид ажлын хэт ачаалалтай ажиллаж байгаа нь харагдаж байна.



Зураг 12. Согтуугаар гэмт хэрэг үйлдэгдэж байгаа газар 2013-2017 он

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 39.4 хувь нь гэр орон сууцанд, 26.4 хувь нь гудамж талбайд, 15.2 хувь нь олон нийтийн газар үйлдэгдсэн байна. Согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийг улирлаар нь харуулбал 33.7 хувь нь өвөл, 31.9 хувь нь хавар, 16.6 хувь нь зун, 17.6 хувь нь намар; 1,2,3,4,5,6,12 саруудад илүүтэй үйлдэгджээ. Гариг, цагаар нь харуулбал даваа, мягмар, лхавга, баасан гаригуудад гэмт хэрэг 19-06 цагийн хороонд илүүтэй үйлдэгджээ.







Зураг 13. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн цаг хугацаа 2013-2017 он

ДӨРӨВ. СОГТУУГААР ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХҮН:


Улсын хэмжээнд 2013-2017 онд нийт 27097 хүн согтуугаар гэмт хэрэг үйлдсэний 12127 нийслэлд, 14970 орон нутагт үйлдэгдсэн байна. Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн 1783 буюу 6.5 хувь нь эмэгтэй, 435 буюу 1.6 хувь нь хүүхэд, 24879 буюу 92.2 хувь нь эрэгтэйчүүд байна.



Зураг 14. Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн нутаг дэвсгэр, 2013-2017 он



Хүүхэд, эмэгтэйчүүдээс согтуугаар үйлдсэн, согтуугаар бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг жил дарааллан буурч, согтуугаар гэр бүлийн хүчирхийллийг үйлдэх гэмт хэрэг өссөн бөгөөд 2013 онд 322 хүн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байсан бол 2017 онд 566 болж, 56 хувиар өссөн байна. Энэ нь бие даасан хууль батлагдсан, иргэдийн хуулийн байгууллагад хандах хандлага ихэссэнтэй холбоотой гэж дүгнэж байна.



Зураг 15. Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн нас, 2013-2017 он

Согтуугаар 2013-2017 онд гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн насны байдлыг харуулбал: 12682 буюу 46.8 хувь нь 18-29 нас, 8302 буюу 30.6 хувь нь 30-39 насны залуучууд, 14-18 хүртэлх насны 360 хүүхэд, 1813 буюу 6.6 хувь нь эмэгтэйчүүд холбогдон шалгагджээ.

Дээрх үзүүлэлтээс харахад 18-39 насны залуус 77.4 хувийг эзэлж байгаа нь сурч, боловсрох, хийж бүтээх насандаа архидан согтуурч, гэмт хэрэгт холбогдож байгааг харуулж байна.

Хүүхэд, залуусын дунд архины хэрэглээ бий болсныг “Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан эрсдэлт хүчин зүйлийн тархалтын судалгаа”²⁹-нд дурьдсан байх бөгөөд 15-24 насны хүн амын 26.7 хувь нь сүүлийн 30 хоногт архи хэрэглэсэн, 21.4 хувь нь сүүлийн 12 сард архи хэрэглэсэн гэжээ. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс 2012 онд хийсэн судалгаанд хамрагдсан нийт 530 залуусын 446 нь буюу 84.1 хувь нь согтууруулах ундаа хэрэглэж үзсэн, 226 залуусын 50.7 хувь нь тэмдэглэлт арга хэмжээний үеэр бусдын нөлөөнд автан хэрэглэсэн, 16-18 насны гурван хүний нэг нь 14-16 наснаас согтууруулах ундааг хэрэглэдэг гэж хариулсан байна.




Зураг 16. Гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн нийгмийн байдал, 2013-2017 он

Согтуугаар гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 53.5 хувь ажилгүй, 24.6 хувь нь хувийн хэвшилд буюу хувиараа бизнес эрхлэгч, 10 хувь нь малчин, 4.5 хувь нь төрийн албан хаагч, 3.3 хувь нь оюутан байна.


²⁹ Нийслэлийн эрүүл мэндийн газраас хийсэн судалгаа 2009 он

ТАВ. СОГТУУГААР ҮЙЛДЭГДСЭН ЗӨРЧИЛ, БУСАД МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ


Улсын хэмжээнд 2013-2017 оны байдлаар согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ нийт 260965 захиргааны зөрчил үйлдсэн. Зөрчлийн тоо урьд жилүүдэд буурах хандлагатай байсан ч 2017 онд 45746 зөрчил согтуугаар үйлдэгдсэн нь урьд онтой харьцуулахад 5.5 хувиар өссөн байна.



Зураг 17. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ үйлдсэн захиргааны зөрчил, 2013-2017 он




Зураг 18. Эрүүлжүүлэгдсэн нутаг дэвсгэр, 2013-2017 он



Зураг 18. Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн хүйсээр нь харуулбал 2013-2017 он

Улсын хэмжээнд 2013-2017 онд 513.882 хүн эрүүлжүүлэгдсэний 214.023 буюу 41.6 хувь нь орон нутагт, 299.859 буюу 58.3 хувь нь нийслэлд байх бөгөөд 28571 буюу 5.5 хувь нь эмэгтэйчүүд, 2443 буюу 0.4 хувь нь насанд хүрээгүй хүн байна. Эрүүлжүүлэгдсэн хүн 2013 онд 123.454 хүн байсан нь 2017 онд 86.497 болж 32.3 хувиар буурчээ. Эрүүлжүүлэгдсэн эмэгтэйчүүд 2016 онд 1214, 2017 онд 3011 болсон нь 40,3 хувиар өссөн байх бөгөөд Төмөр зам дахь Цагдаагийн газрын

Албадан эрүүлжүүлэх байранд эрүүлжүүлэгдсэн эмэгтэйчүүдийн дунд 2017 онд хийсэн судалгаагаар жилд 3-10 удаа эрүүлжүүлэгдсэн 98 эмэгтэй байна³⁰ гэжээ.




Зураг 19. Сайн дурын болон албадан эмчилгээнд явсан хүн, 2013-2017 он

Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн дундажаар архинд донтох өвчтэй, архины эсрэг эмчилгээ шаардлагатай 100,000 хүн байгаагаас 10 орчим хувь нь эмчилгээнд хамрагджээ³¹. 2017 онд 2668 хүн сайн дурын эмчилгээнд хамрагдсан нь урьд жилүүдээс 4 дахин нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байна.

Архины архаг хэрэглээтэй хүмүүст авах арга хэмжээ хангалтгүй байгааг нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтсүүд анхаарах шаардлагатай байх бөгөөд орон нутгийн цагдаагийн газарт ажиллаж байгаа урьдчилан сэргийлэх ахлах байцаагч нараас сайн дурын болон албадан эмчилгээнд явуулах хүмүүсийн зардлын асуудал шийдэгдэхгүй хүндрэл учирдаг талаар ярьж байна.

Цагдаагийн байгууллагад иргэдээс ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага, мэдээлэлд сүүлийн 5 жилийн байдлаар нийт 3.038.123 дуудлага, мэдээлэл бүртгэгдсэний 1.466.978 буюу 48.2 хувь нь 08.00-20.00 цагт, 1.571.145 буюу 51.7 хувь нь 20.00 – 08.00 цагт бүртгэгдсэн байна.




Зураг 20. Нийслэлийн хэмжээнд архидан согтуурахтай холбоотой дуудлага, мэдээлэл, 2013-2017 он

ЦЕГ-ын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэрэг, зөрчил, гал түймэр, гамшиг осол, эмнэлэгийн яаралтай тусламжийн тусгай дугаарын утаснуудад тусламж хүссэн дуудлага ирдэг бөгөөд 2013-2017 онд архины хордлогын дуудлага 35869 ирсэн нь жил ирэх тусам өссөн байх тул архийг хэтрүүлэн хэрэглэх явдал ихэссэн гэж дүгнэж болохоор байна.


³⁰ Төмөр зам дахь Албадан эрүүлжүүлэх байрны танилцуулга

³¹ Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн тайлан



Зураг 21. Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 103 тусгай дугаарын утсанд иргэдээс архины хордлогын улмаас яаралтай тусламж хүссэн дуудлага, 2013-2017

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн судалгаагаар 2016 онд 77890 хүн үйлчлүүлснээс 11257 буюу 13.1 хувь нь согтуу, 2017 онд 84530 хүн үйлчлүүлснээс 14.1 буюу 11919 хүн архидан согтуурсаны улмаас бэртэж гэмтсэн байх бөгөөд урьд онтой харьцуулахад 5.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.³²



Зураг 22. Гэмтэл согог судлалын үндэсний төвөөр үйлчлүүлсэн иргэд:

ЗУРГАА. МОНГОЛ УЛС ДАХЬ АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14.3 дахь хэсэгт Согтууруулах ундаа худалдах, хэрэглэх, түгээр үйлчлэх талаар тогтоосон журмын биелэлтэд цагдаагийн байгууллага, бүх шатны Засаг дарга нар хууль, тогтоомжийн бусад актаар олгосон эрх хэмжээний дагуу хяналт тавихаар заасан хэдий ч архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчсөн аж, ахуй нэгж байгууллага, хуулийн этгээдийн зөрчлийг цагдаагийн байгууллага илрүүлэн шалгаж, материалыг Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяаллын дагуу аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт шилжүүлэн ажиллаж байгаа нь хуулийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байна.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдаас АСТТ Хуулийг зөрчсөн аж ахуй нэгж, байгууллага, хуулийн этгээдийг илрүүлсэн хэдий ч хариуцлага тооцох механизм байхгүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй, хариуцлага тооцуулахаар аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлсэн материалын дагуу арга хэмжээ авсан талаар цагдаагийн байгууллагад албан ёсоор хариу мэдэгддэггүй, хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүй байна. Цагдаагийн алба хаагчдад энэ хуулиар хариуцлага хүлээлгэх зүйл, заалт байхгүй байгаа нь хяналт алдагдах нөхцөл болж байна гэж үзэж болохоор байна.

³² Нийслэлийн цагдаагийн газрын танилцуулга

Зөрчлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйл “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль зөрчих”-д цагийн хязгаарын талаар дурдаагүйн улмаас цагийн хязгаар зөрчсөн аж ахуйн нэгжүүдийг шөнийн цагаар хэтрүүлэн ажилласан тохиолдолд хариуцлага хүлээлгэх заалтгүй, одоогоор Зөрчлийн тухай хуулийн 10.4 дүгээр зүйл “Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих”, 10.4.2 дахь “Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хориглосон газар, цэгт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэх заалтаар хариуцлага тооцож байгаа нь хангалтгүй байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.3-т Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг авсны үндсэн дээр батална гэсэн хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь нийслэлийн 1 хороонд 30 - 50, орон нутгийн 1 суманд 10-15 аж ахуйн нэгж архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ үзүүлж байгаагаас харагдаж байна.

Зөрчлийн тухай хуулийн 5.2-т Танхайрах зөрчлийн шинжийг тусгахдаа “Олон нийтийн газарт” гэж тусгаж өгсөн нь гэр хороолол, ахуйн орчинд танхайрсан, амгалан тайван байдал алдагдуулсан, хэрүүл маргаан үүсгэсэн зөрчлийг ЭХҮ-аас татгалзах байдлаар шийдвэрлэж байгаа нь зөрчил гаргагчдыг өөгшүүлэх, дахин зөрчил үйлдэгдэх, цаашид гэмт хэрэг үйлдэх боломж, нөхцлийг бүрдүүлж байна.

ДҮГНЭЛТ

1. Архидан согтуурснаас үйлдэгдсэн гэмт хэрэг сүүлийн 5 жилийн байдлаар 6.6-27.3 хувиар, согтуугаар үйлдсэн зөрчил, саатуулагдсан хүн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлүүд буурсан статистик мэдээ гарч байна. Энэ нь иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилж, архины хор холбогдлын талаар ухамсарлан, аливаа тэмдэглэлт баярыг архидан согтуурах бус амарч, зугаалах, явган аялах зэргээр өнгөрөөх эерэг нөлөөлөл нийгэмд дэлгэрч байгаа хэдий ч архины үйлдвэрлэл, импорт нэмэгдэн, реклам, зар сурталчилгаа идэвхжсээр байгаа учир хэрэглээ буурахгүй байна. Өсвөр үе, залуучуудын дунд архины хэрэглээ нэмэгдэн, гэр бүл салах, улмаар архидан согтуурсан үедээ гэмт хэрэг үйлдэж, харгис хэрцгий байдлаар хүний амь нас, эрүүл мэндийг хохироох зэргээр нийгэмд хор уршиг тарьсаар байх тул онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай байна.
2. Нийгэмд ажилгүйдэл дагасан архидалт, архины архаг хамааралтай хүмүүс ихсэн, айдас, бухимдал, үл ойлголцол, гэр бүлийн орчинд хүчирхийлэл үйлдэгчид нэмэгдэж байгаа тул архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр Засаг захиргааны бүх нэгж, Хууль хяналтын болон эрүүл мэндийн байгууллага, төрийн бус байгууллага, айл өрх, иргэн бүрийн анхаарч, идэвхитэй хамтран ажиллах зайлшгүй хэрэгцээ, шаардлага байна.
3. Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр гарсан хууль, Засгийн газрын тогтоол, Төрийн захиргааны төв болон орон нутгийн засаг захиргааны нэгжийн шийдвэр, захирамж гарч, хууль эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч хууль тогтоомжийн хэрэгжилт, хяналт шалгалтын чанар, үр нөлөө хангалтгүй, Хил, Гааль, Мэргэжлийн хяналт, Цагдаагийн байгууллагууд хамтарсан болон дагнасан

шалгалт хийх төдийхнөөр хязгаарлагдаж, цаашид шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх ажлын уялдаа холбоо муутай, хууль зөрчигчдөд цагдаагийн байгууллагаас арга хэмжээ авах хуулийн заалт хүчингүй болсон зэрэг нь архидалттай тэмцэх ажилд сөргөөр нөлөөлж байна.

4. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Аж ахуйн нэгжийн зөвшөөрлийн тухай хуулиар архи, дарс, шар айраг, спиртийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх асуудлыг хуульчлан зохицуулсан бөгөөд Худалдаа үйлдвэрлэлийн сайдын 2005 оны 05 тоот тушаалаар зохицуулагдаж байсан 1000 хүн ам тутамд ноогдох согтууруулах ундаа зарж, борлуулах цэгийн тоог тогтоосон эрх зүйн акт одоогоор хүчингүй болж, хяналт алдагдсанаас худалдаалах цэгийн тоо хэт олширсон. Иймд улсын хэмжээнд нэгдсэн бүртгэл судалгаа гаргаж, согтууруулах ундаа борлуулах цэгийн тоог бодитой тогтоох зайлшгүй шаардлагатай байна. /тухайлбал: орон нутагт 1 суманд 3-15 архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулдаг дэлгүүр ажиллаж байна/
5. Согтууруулах ундааны импорт, дотоодын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбар хоорондын зохицуулалтыг үндэсний хэмжээнд уялдуулж, нэгдсэн бодлого гарган, удирдлагаар хангаж ажиллах цахим нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бий болгох хэрэгцээ тулгарч байна.
6. Сүүлийн 5 жилд 508.1 сая литр согтууруулах ундаа үйлдвэрлэж, 232.5 сая литрийг импортоор оруулсан нь 18-аас дээш насанд хүрсэн 1.9 сая хүн амтай³³ манай улсын тухайд хэтэрхий өндөр хэрэглээ юм.
7. Улсын хэмжээнд сүүлийн 5 жилд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 53.5 хувийг ажилгүйчүүд эзэлж, гэмт хэргийн 39.4 хувь нь ахуйн хүрээнд согтуугаар үйлдэгдсэн байна. Нийт согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 54.4 хувийг Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг эзэлж байх тул урьдчилан сэргийлэх ажлыг энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд чиглүүлэх нь зүйтэй байна.
8. Судалгаагаар гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн 46.8 хувь нь 18-29 насны, 30.6 хувь нь 30-39 насны залуучууд, 14-18 хүртэлх насны 360 хүүхэд согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна. Сурч боловсрох, хийж бүтээх насны залуус архидан согтуурч улмаар гэмт хэрэгт холбогдож байгаа нь өсвөр үе, залуучуудад архины хор холбогдлын талаар мэдээлэл хүрдэггүй, эцэг эхээс тавих хяналт суларсан, залуучууд өөрийгөө хөгжүүлэх, цагийг үр дүнтэй өнгөрөөх талаар идэвхи санаачлага, хичээл зүтгэл хангалтгүй байна. Иймд хүүхэд залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ анхаарлаа хандуулж хамтран ажиллах зайлшгүй хэрэгцээ бий болсон байна.
9. Архины албадан болон сайн дурын эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эмчилгээ хийлгэх хүсэлтэй хүмүүст үйлчилгээ үзүүлэх, хөдөө орон нутгийн архины хамааралтай хүмүүсийг албадан эмчилгээнд явуулах, орчиндоо түгшүүр төрүүлж, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг хүмүүстэй хуулийн дагуу хариуцлага тооцох зэрэг ажлыг идэвхижүүлэх шаардлагатай байна.
10. Архины эсрэг үйл ажиллагаа явуулдаг 50 гаран ТББ-ын үйл ажиллагаа зогссон³⁴ гэх судалгаа байх тул төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан иргэдэд төлөвшүүлэх, архины хор

³³ Гэмт хэргийн цагаан ном, www.1212.mn

³⁴ Аюулгүй байдлын судлаач Ж.Цогтсугарын илтгэл

холбогдлын талаарх сургалтыг шаталсан хэлбэрээр явуулах хэрэгцээ шаардлага байна.

11. Цагдаагийн газар, хэлтсийн урьдчилан сэргийлэх ахлах байцаагч архидан согтуурахтай тэмцэх ажлыг анхан шатны нэгжид хавсарган гүйцэтгэж байгаа нь энэ чиглэлээр зохион байгуулах болон хяналт тавих ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хууль зүй, Дотоод хэргийн яам: - Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах.

Найман нэрийн барааны дэлгүүрээр архи согтууруулах ундааг худалдаалах бус төрөөс архины дагнасан дэлгүүрийг нутаг дэвсгэрийн хүн амын тоотой уялдуулан тогтоож ажлуулах, олсон орлогын тодорхой хувийг архидан согтуурахтай тэмцэх болон эмчлэх чиглэлээр зарцуулах саналыг Засгийн газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулах.

Архи согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, олсон орлогын тодорхой хувийг согтууруулах ундааны хор уршгийг олон нийтэд хүргэх ухуулга, сургалт, сурталчилгааны ажилд зарцуулдаг болгох талаар судалж, зохих шийдвэр гаргуулах.

Энэхүү судалгаанд суурилсан чиглэлийн эрдэмтэдийн багийн санал зөвлөмж, аргачлалыг боловсруулж, улсын хэмжээнд холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх.

Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам: - Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг хэрэгжүүлж “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, нормативыг тухайн орон нутгийн хүн амын тоо, байршилтай уялдуулан тогтоож, хяналтыг сайжруулах.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам: - Өсвөр насны хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг өнгөрөөх, сурч боловсрох идэвхийг өрнүүлэх, үндэсний өв соёлоо дээдэлж, хорт муу зуршлаас татгалзах чиглэлээр сургалтын ажлуудыг зохион байгуулах.

Эрүүл Мэндийн яам: - Архины сайн дурын эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эмчилгээ хийлгэх хүсэлтэй хүмүүст үзүүлэх үйлчилгээг сайжруулах.

Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч: - Харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг газар нутгийн байршил, онцлог, хүн амын тоотой уялдуулан тогтоох.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгох болон сунгахдаа тухайн аж ахуйн нэгжийн хуулийн хэрэгжилт, цагдаагийн байгууллага болон эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг харгалзан олгох.

Хэвлэл мэдээллийн байгууллага: - Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9.2, Зар сурталчилгааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлж, нийгмийг сэтгэл зүйд эерэг нөлөөлөл үзүүлэхүйц кино, нэвтрүүлэг, сургамжит өгүүллэг, мэдээ, мэдээлэл, шторкыг тогтмол явуулж, хүүхэд залуусыг соён гэгээрүүлэх чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлэх.

Цагдаагийн байгууллага: - Согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийг бууруулах чиглэлээр дараах ажлыг зохион байгуулах санал, зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Нийтийн хэв журам хамгаалах алба, Урьдчилан сэргийлэх хэлтсээс архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтсийг мэргэжлийн удирдлагаар ханган, улсын хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг үйлчилгээний газруудын судалгааг нарийвчлан гаргаж, худалдаа үйлчилгээний цэгийн тоог багасгах, цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох, худалдан борлуулах, үйлчилгээ үзүүлэх газрын стандарт тогтоолгох саналуудыг холбогдох яам, агентлаг, орон нутгийн Засаг захиргаанд хүргүүлж, шийдвэрлүүлэх.

2. Урьдчилан сэргийлэх хэлтэс согтууруулах ундааны импорт, дотоодын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбар хоорондын зохицуулалтыг үндэсний хэмжээнд уялдуулж, нэгдсэн бодлого гарган, удирдлагаар хангаж, ажиллах цахим нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг бий болгох ажлыг судлаж, холбогдох газарт саналыг хүргүүлэх.

3. Урьдчилан сэргийлэх хэлтэс болон нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсээс байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд архидан согтуурах, аливаа хорт зуршлаас татгалзах уриалга, хөдөлгөөн өрнүүлэх. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулж байгаа архи согтууруулах ундааны сурталчилгаанд хяналт тавьж, зөрчигчдөд хариуцлага тооцох.

4. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүд хууль зөрчин үйл ажиллагаа явуулсан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлж, хууль бус орлогыг тодорхойлон улсын орлого болгох, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах.

5. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийслэлийн эрүүл мэндийн газар

6. бусад төрийн бус байгууллагуудтай хамтран архидан согтуурч, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, архины хамааралтай иргэдэд хуулийн болон ёс суртахууны чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг үр дүнтэй байдлаар зохион явуулахын зэрэгцээ хуулийн дагуу шаталсан арга хэмжээг эрчимжүүлэх.

7. Урьдчилан сэргийлэх хэлтсээс өсвөр үеийнхнийг хорт зуршилд автахаас сэргийлэх, учирч байгаа хүндрэл, бэрхшээл, хэрэгцээ шаардлагын талаар санал асуулга авч, зохион байгуулалтын ажлуудыг төрийн болон судалгааны, төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

8. Замын цагдаагийн албанаас согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохоос урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлээр хяналт шалгалт хийх техник, хэрэгсэл, технологийн дэвшил, иновацийг нэвтрүүлэх чиглэлээр судалж, хэрэгжүүлэх.

9. Сар бүрийн 1-ний өдрийг “Архигүй өдөр” болгосон нь үр дүнгээ өгч байгаа тул долоо хоногийн 1 өдрийг согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ явуулахыг хориглож, архидалтын эсрэг арга хэмжээг идэвхжүүлэн зохион байгуулах саналуудыг танилцуулж байна.

МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ АЛБАНЫ
ДҮН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС